



I-XII/2021

Тархаасан: 2022 оны 2 дугаар сарын 14




Нийтийн хоолны салбарын орлого өмнөх оноос 8.9 хувиар өсжээ

Нийтийн хоолны салбарын орлого 2021 онд 661.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 53.9 тэрбум төгрөг буюу 8.9 хувиар өсжээ. Үүнд рестораны орлого 38.8 (11.3%) тэрбум төгрөг, захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлого өмнөх оноос 7.1 (5.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны 11 дүгээр сард 75.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.1 (1.5%) тэрбум төгрөг, 12 дугаар сард 91.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 16.4 (21.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО,
төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эцэст



Рестораны орлогын эзлэх хувь өмнөх оноос 1.3 нэгж хувь, баарных 0.1 нэгж хувиар өсөж, харин гуанзных 0.8 нэгж хувь, захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогын эзлэх хувь 0.5 нэгж хувиар тус тус буурсан байна.


Зочид буудлын салбарын орлого өмнөх оноос 25.9 хувиар өсжээ

Зочид буудлын салбарын орлого 2021 онд 230.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 47.3 тэрбум төгрөг буюу 25.9 хувиар өсжээ. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 26.8 (21.9%) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудал болон амралтын газрын орлого 19.9 (34.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын орлого 2021 оны 11 дүгээр сард 26.6 тэрбум төгрөг болж өмнөх сараас 2.0 (6.9%) сая төгрөгөөр буурч, харин 12 дугаар сард 47.4 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 20.7 (77.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 12.1 (68.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын 2021 оны орлогын 64.8 хувийг 3 ба түүнээс дээш одтой зочид буудал, 33.4 хувийг зэрэглэлгүй зочид буудал, амралтын газар, 1.9 хувийг 2 одтой зочид буудлын орлого эзэлж байна.

ЗУРАГ 2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО, зэрэглэлээр, тэрбум төгрөг, жил бүрийн эцэст



Ойлголт, тодорхойлолт:

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна. Зочид буудлын үйл ажиллагаанд зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.



Эх үүсвэр:

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал.

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гаргах хуваарь:

2022 оны 3 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329278

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Ч.Мөнхтуул
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212